

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ 2017 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй тус Хорооны зохицуулалттай байгууллагууд болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн байгууллагуудын харилцагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд судалгаа, дүн шинжилгээг хийлээ.

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 86 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилбал:

Үнэт цаасны салбарт – 36

Даатгалын салбарт – 38


Банк бус санхүүгийн салбарт – 7

Хадгаламж зээлийн хоршооны салбарт – 5 өргөдөл, гомдол тус тус ирүүлсэн байна.

Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 14 хоног байна.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг салбар тус бүрээр графикаар харуулбал:

График 1



### 1. Үнэт цаасны салбарт ирүүлсэн өргөдөл, гомдол:


Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 36 өргөдөл, гомдол ирснээс 23 өргөдөлд хууль, журмын дагуу хянаж холбогдох хариуг өгсөн бөгөөд 13 өргөдөл хяналтын шатандаа судлагдаж байна.

Өргөдөл, гомдол шийдвэрлэхэд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК, үнэт цаасны компаниудаас тогтмол холбогдох тайлбар, материалыг гаргуулан авч ажилладаг.

Дээрх өргөдөл, гомдолд хувьцаат компанийн ногдол ашиг, хувь болон үйл ажиллагаатай холбоотой, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой, брокер, дилерийн компаниар эзэмшигчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаатай холбоотой, хамтын сантай холбоотой өргөдлүүд ирсээр байна.

Нийт ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилбал:

График 2




Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж дараах мэргэжлийн оролцогч байгууллагуудад харилцагчдын хохирлыг барагдуулах үүрэг өгч хохирлыг барагдуулан ажиллаж байна.

Үнэт цаасны салбарт ирж буй нийт өргөдлийн 39 хувь нь эзэмшигчийн зөвшөөрөлгүй хийгдсэн арилжаа эзлэж байгаа бөгөөд үүнээс 44 хувь нь тус Хорооны тусгай зөвшөөрөл эзэмшигч буй үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 3 брокер, дилерийн

компаниудаар дамжуулан арилжаалагдсан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон 4 брокер, дилерийн компаниар дамжуулан хийгдсэн гэх өргөдөл, гомдол 56 хувийг эзэлж байна.

2017 нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл, гомдлын тоог 2016 оны нэгдүгээр улиралд ирүүлж байсан тоотой харьцуулахад 31 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 5



## **2. Даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл, гомдол:**


Тус Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасны дагуу чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан, өргөдөл гомдол 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 38 ирж үүнээс 32 өргөдөл гомдол хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэгдсэн бөгөөд 6-н өргөдөл, гомдол хянагдаж байна. Дээрх өргөдөл гомдлыг даатгалын төрлүүдээр авч үзвэл Жолоочийн хариуцлагын албан журмын, Автотээвэр буюу Тээврийн хэрэгслийн, Орон сууц, зээлдэгчийн гэнэтийн ослын /ипотек/, Мэргэжлийн хариуцлагын, Мал амьтны даатгал мөн даатгалын хохирол үнэлгээний тайлангийн талаар ирүүлсэн гомдлыг хуулийн дагуу урьдчилан шийдвэрлэж нийт 15,097,473.00 (арван таван сая ерэн долоо мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлж ажилласан байна.

2017 нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл, гомдлын тоог 2016 оны нэгдүгээр улиралд ирүүлж байсан тоотой харьцуулахад 52,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны нэгдүгээр улирлын байдлаар даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүн төрлүүдээр ангилан харуулбал Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 39 хувь буюу хамгийн өндөр байх бөгөөд Тээврийн хэрэгслийн даатгал 26 хувь, харин орон сууцны, зээлдэгчийн эрсдэлийн буюу ипотекийн даатгал 21 хувийг эзэлж байна.

➤ ХШЗГ-т ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр харуулав.

График 8



2017 оны нэгдүгээр улиралд даатгалын салбарт иргэн, аж ахуйн, нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь урьдчилан шийдвэрлэж нийт 15,097,473.00 (арван таван сая ерэн долоо мянга дөрвөн зуун далан гурав) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг төлүүлэн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж ажилласан байна.

Даатгалын салбарт 2017 оны нэгдүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулбал 52,6 хувиар буурсан бөгөөд нийт өргөдөл гомдлоос даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй нь 26 буюу 81,25 хувь, үндэслэлгүй нь 6 буюу 18,75 хувийг тус тус эзэлж байна. Дээрхээс дүгнэвэл даатгалын компани нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан байдал нь эрс буурсан мөн олгохоос татгалзсан тохиолдлын ихэнх тохиолдол нь хууль зүйн үндэслэлтэй татгалзсан байна.

**1. Банк бус санхүүгийн байгууллагын салбарт ирүүлсэн өргөдөл гомдол.**


2017 оны 01 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн салбартай холбоотой нийт 7 өргөдөл гомдол ирснээс 5 өргөдөл гомдол нь хуулийн хугацаандаа шийдвэрлэгдэж, 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна. 2017 оны нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл гомдлын тоог 2016 оны мөн үеийнхтэй харьцуулахад 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Дээрх өргөдөл гомдлыг төрлүүдээр нь авч үзвэл төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн, зээлийн мэдээллийн санд буруу бүртгэсэн болон хасалт хийгдээгүй байгаа, талаарх өргөдөл гомдлууд ирсэн байна.

**2. Хадгаламж зээлийн хоршооны салбарт ирүүлсэн өргөдөл гомдол.**

Тус салбарт 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 5 өргөдөл гомдол ирүүлсэн ба үүний 3 өргөдөл гомдол нь хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой, бусад нь лавлагаа, тодорхойлолт гаргуулах тухай хүсэлт байна. Дээрх 3 өргөдөл гомдол нь Хорооноос тухайн хоршоонд тавьж буй хяналтын талаар, баталсан хоршоодтой холбоотой дүрэм журмыг өөрчлөн шинэчлэх болон барьцааны гэрээ цуцлагдаагүй байгаа талаарх гомдлууд ирсэн бөгөөд, хугацаанд нь шийдвэрлэсэн байна. 2017 оны нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл гомдлын тоог 2016 оны мөн үеийнхтэй харьцуулахад 55 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бичил санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудад хандан ирүүлж буй өргөдөл, гомдлын тоо бусад хоёр салбартай харьцуулбал бага боловч 2017 оны нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл гомдлын тоог өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулахад 54 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 9



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН  
ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛ**